



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2026.05.11 № 01/4982
танай 2026.04.20 -ны № 18 -Т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны эрүүл мэндийн салбарын зардал, санхүүжилттэй холбогдуулан ирүүлсэн асуулгатай танилцаад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Асуулга-1: Эрүүл мэндийн салбарын төсвийг нэмэгдүүлэх бодлого нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ямар зарчим, шалгуур үзүүлэлтэд үндэслэн ямар тооцооллын аргачлалд тулгуурлан төлөвлөсөн талаар дэлгэрэнгүй мэдээлэл;

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулахаар, 8.1.4 дэх заалтад Улсын Их Хурал тус төсвийн бодлогын баримт бичгийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлахаар тус тус заасан.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ, нийт зарлагын дээд хэмжээ, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл зэрэг макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүд батлагддаг бөгөөд энэ хүрээнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн төсвийн төслийг боловсруулж, салбаруудад төсвийн хуваарилалтыг хийдэг.

Тодруулбал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах үйл явц нь дээрээс доош чиглэлтэй тул эрүүл мэндийн салбарын төсвийг нэмэгдүүлэх асуудлыг тус төсвийн бодлогын баримт бичигт тусгайлан тусгадаггүй болно.

Асуулга-2: “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эрүүл мэндийн салбарын төсвийг 2027 онд Дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьд хүргэх зорилтыг тусгасан, дээрх зорилтыг хэрхэн хангах талаарх тооцоо, төлөвлөлтийн талаар;

Улсын Их Хурлын 2025 оны “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 109 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар

батлагдсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-д эрүүл мэндийн салбарын төсвийг 2027 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьд хүргэх зорилтыг тусгасан хэдий ч төсвийн нийт зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2024 оны суурь түвшин болох 38.3 хувиас үе шаттайгаар бууруулж, 2027 онд тус хэмжээг 30 хувьд хүргэх зорилт тусгагдсан.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалтад санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн жилийн төсвийн саналыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэхээр зохицуулсан.

Тодруулбал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээнд багтаан Сангийн яам нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний болон хууль тогтоомжид заасан төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг жилийн төсвийн төсөлд тусгадаг.

Нэг талаас төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг үе шаттайгаар бууруулах, нөгөө талаас эрүүл мэндийн салбарын төсвийг нэмэгдүүлэх зорилт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нэгэн зэрэг туссан учраас хэрэгжилтийг хангахын тулд бусад салбарын хууль тогтоомжид заасан чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг зайлшгүй танах шаардлагыг бий болгож байна.

Энэхүү зөрчилтэй нөхцөл байдлыг засаж, сайжруулахын тулд төсөвт зардал нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хууль тогтоомжийг цэгцлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд төсвийн зарлагын дээд хязгаар, эдийн засгийн нөөц боломж, төсвийн орлогын бүрдлээс шалтгаалан төсвийн зарлагыг тусгайлан зориулалт, хувь хэмжээ заан урьдчилан хуваарилахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Нөгөөтээгүүр төсвийн хуваарилалтыг хийхдээ зөвхөн хэрэгцээнд сууриллахаас гадна тухайн салбарын үйл ажиллагааны бодит үр дүн, гүйцэтгэлтэй уялдуулан төсвийг нэмэгдүүлэх нь хэмнэлт-үр ашиг бий болгох, төсвийн хариуцлагыг сайжруулах, төрийн бүтээмж болон үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хөшүүрэг болдгийг харгалзан үзэх нь зайлшгүй юм.

Эрүүл мэндийн салбарын тухайд 2021 оны төсвийн жилээс хэрэгжүүлсэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцооны шинэчлэл нь эрүүл мэндийн салбарт удаан хугацааны туршид бий болсон үр ашиггүй тогтолцоог зайлшгүй шинэчлэх шаардлагатайг харуулж, үүнээс үүдэлтэй сөрөг нөлөөллүүдийг ил гаргасан.

Ийнхүү илэрсэн эрүүл мэндийн салбарын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд салбарын төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхээс илүүтэйгээр өнөөгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохицуулалт, зохион байгуулалт болоод эрүүл мэндийн тогтолцооны удирдлага, зохион байгуулалт, засаглал, санхүүжилтийн хүчин зүйлсээр дамжуулж салбарын үргүй зардлыг бууруулах, санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Асуулга-3: Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн нэмэгдлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сангийн яамнаас тооцоолж буй төсөв, бодлогын байр суурь, уг нэмэгдлийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсвийн хүрээнд хэрэгжих боломж, дунд хугацаанд тогтвортой хадгалах санхүүгийн чадавхын талаар;

Засгийн газрын 2025 оны "Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 224 дүгээр тогтоолоор батлагдсан төсөвтөө багтаан салбарын ажилчдын үндсэн цалинг нэмэгдүүлэн тогтоохыг Эрүүл мэндийн сайдад зөвшөөрсөн. Мөн Засгийн газрын 2025 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 225 дугаар тогтоолоор цалин хөлсний нэмэгдлийг Эрүүл мэндийн сайдын тогтоосон үндсэн цалингаас бус Засгийн газраас тогтоосон албан тушаалын цалингийн доод хэмжээнээс тооцож олгохоор зохицуулсан.

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалинг хоёр янзаар тогтоосон нь үндсэн цалингаас бодож олгох нэмэгдлийг тооцоход ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн. Тус асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны 135 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолоор тогтоосон хэмжээнээс 30 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, тус асуудлыг 2026 оны батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайдад даалгасан.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 190.3 тэрбум төгрөгийн эх үүсвэр төсөвт батлагдсан.

Мөн Эрүүл мэндийн даатгалын сангийн он дамнасан өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2025 оны төсвийн жилд тус сангийн зарлагыг 2024 оноос 360.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн. Улмаар 2025 оны төсвийн жилд сангийн батлагдсан төсвөөс өмнөх оны хуримтлагдсан өр төлбөр болох 316.8 тэрбум төгрөгийг барагдуулсан.

Харин Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд үүссэн өр төлбөр 198.3 тэрбум төгрөг гарсан бөгөөд тус сангийн 2025 болон 2024 онд үүссэн өр төлбөрийн зөрүүгээс 118.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр суларч байна.

Тодруулбал, 2026 онд салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор төсөвт нэмэлтээр тусгасан 190.3 тэрбум төгрөг болон Эрүүл мэндийн даатгалын сангийн дээрх хоёр оны өр төлбөрийн зөрүүгээс суларсан 118.5 тэрбум төгрөг буюу нийт 308.8 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр 2026 онд эрүүл мэндийн салбарын ажилчдын үндсэн цалин хөлс, нэмэгдлийг шийдвэрлэх боломжтой байна.

Үүний зэрэгцээ эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээг Эрүүл мэндийн сайдын батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, дунд хугацаанд салбарын төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж, эмчээс бусад төрийн албан хаагчдын орон тоог бууруулан, чиг үүргийн давхардлыг арилгаж, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааг нягтаршуулах, зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын багцаас хасах, сонгон шалгаруулалт, гэрээлэлтийг оновчтой болгох замаар шаардлагагүй зардлыг бууруулах зэрэг арга хэмжээг давхар авч хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны “Бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 06 дугаар албан даалгаврын 10.2-т “Төрийн албан хаагчийн үндсэн цалингийн сүлжээ, нэмэгдэл, нэг удаагийн буцалтгүй тусламж, урамшуулал, тэтгэмж олгох нөхцөл, хугацаа, давтамж, хэмжээг салбар харгалзахгүйгээр төрийн албан хаагчид тэгш, шударга үйлчилдэг байх зорилгоор төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг зохицуулсан салбарын хууль тогтоомжийг хүчингүй болгож Төрийн албаны тухай хуулиар зохицуулах, түүнчлэн Нийтийн албаны тухай хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулах”-ыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан.

Эрүүл мэндийн салбарт 2021 оны төсвийн жилээс эхлэн барилга байгууламж, орон тоо санхүүжүүлдэг тогтолцооноос гарцад чиглэсэн буюу хийсэн ажил санхүүжүүлдэг тогтолцоонд шилжсэн учраас цаашид тус салбарын ажилчдад олгох цалин хөлсийг мөн адил зарчмаар буюу ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан байдлаар олгох асуудлыг дээрх хууль тогтоомжийн хүрээнд нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

Хүндэтгэсэн,



З.МЭНДСАЙХАН